

## **“MEDICAL SCIENCE IV INTERNATIONAL CONFERENCE”**

АШУҮИС-ийн салбар сургууль болох Дархан-Уул АУС, Дорноговь АУС, Говь-Алтай АУС хамтран олон улсын хурлыг 2 дахь жилдээ зохион байгуулж байна. “MEDICAL SCIENCE IV INTERNATIONAL CONFERENCE” хурал 2019 оны 10 сарын 14-15 өдрүүдэд Говь-Алтай аймагт хамтран зохион байгууллаа.

Олон улсын эрдэм шинжилгээний хуралд АНУ, ОХУ, АШУҮИС-ийн Цөм лаборатори, БАС, НАСС, МАУОУС, Говь-Алтай, Дорноговь, Дархан-Уул аймаг дахь салбар сургууль, Оточ манарамба зэрэг сургуулийн 100 гаруй судлаачид оролцлоо. Энэхүү хуралд АШУҮИС-ийн Боловсролын асуудал эрхэлсэн тэргүүн дэд захирал Сүмбэрзул оролцсон ба зочин илтгэгчээр МАУОУС-ийн захирал АУ-ы доктор, профессор, ШУА-ы доктор Цэрэндагва, АУ-ы доктор, профессор Чойжамц нар оролцлоо. Хурлын үйл ажиллагаа 2 салбар хуралдаанаар явагдаж 40-өөд илтгэл хэлцэгдлээ. Тус хуралдаанд салбар сургуулийн Эрдэм шинжилгээ хариуцсан ажилтан Д.Сансармаа, ТДС-ын арга зүйч Б.Наранжаргал, Био-Анагаахын тэнхимийн эрхлэгч Д.Янсанжав, багш Ц.Даваачимэг, Ю.Байгалмаа нарын бүрэлдэхүүнтэй баг оролцож 2 аман, 5 постер илтгэл хэлэлцүүлж, Д.Сансармаа хурлын даргаар ажиллав.

Мөн Дорноговь салбар сургуулийн хамт олон тус хуралд ирүүлсэн өгүүллийг хянан эмхэтгэж ЭМШУ сэтгүүлийн тусгай дугаарыг эрхлэн гаргасан байна.